



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/107

Арвайхээр сум

**Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл
олгох тухай**

Боловсролын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 30 дугаар зүйлийн 30.1.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 24/03 дугаар тогтоолын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсрол, шинжлэх ухааны газрын санал, дүгнэлтийг үндэслэн Хужирт сумын Ерөнхий боловсролын 1, 2 дугаар сургуулийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 12 жилээр тус тус олгосугай.

2.Дээрх Ерөнхий боловсролын сургуулиудын сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган, ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Боловсрол, шинжлэх ухааны газар (Г.Пүрэвдорж)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

8224 11 0215